Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

✓	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлагдсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих, шүүхэд төрийг төлөөлөх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах.

Албан тушаалын зорилт:

1.Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

2. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих, шүүхэд төрийг төлөөлөх ажилд эрүүгийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

3. Газар, хэлтсийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Хариуцан гүйцэтгэх- Г Хянах- Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт болон прокурорын хяналтын ажлын бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг үнэлж дүгнэх.	Бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлж, хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулах арга хэмжээ авсан байна.	Г, Х
	1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.	Төлөвлөлтийг оновчтой хийж, биелэлтийг хангуулсан байна.	Г, Х
	1.3.Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийх мэдээлэл, түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүхтэй харилцах чиглэлээр гаргах санал, дүгнэлт, тайлбарын төслийг боловсруулах.	Үндэслэл бүхий мэдээлэл, санал, дүгнэлт, тайлбар боловсруулсан байна.	Г, Х
	1.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журам, зааврын төсөлтэй танилцаж санал өгөх, мөн ирүүлсэн мэдээлэл, албан бичигт тайлбар хийх, зохион байгуулалтын шаардлагатай бусад арга хэмжээг авах.	Үндэслэл бүхий санал, тайлбар боловсруулсан байна.	Г, Х
	1.5.Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл Улсын ерөнхий прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх.	Үндэслэл бүхий санал танилцуулсан байна.	Г, Х
	1.6.Хяналтын ажлын мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлт, үр дүнг тооцох.	Мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж, ажил, арга хэмжээний санал гаргасан байна.	Х, Ш
	1.7.Эрүүгийн хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхтэй холбогдуулан чиглэл авахаар нэгж прокурорын газар болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг шийдвэрлэх.	Үндэслэлтэй шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш

	1.8.Хариуцсан хяналтын чиглэлээр Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд асуудал хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх.	Шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	1.9.Бусад байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	Г
	1.10.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар прокурорын байгууллагаас хүргүүлж буй тайлан, мэдээ, мэдээллийг боловсруулах.	Холбогдох мэдээллийг үндэслэл бүхий боловсруулсан байна.	Г, Х
	1.11.Олон улсын гэрээ, олон улсын байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлангийн хуралд оролцох, Засгийн газраас баталсан Ажлын хэсэгт прокурорын байгууллагыг төлөөлөх.	Прокурорын байгууллагын төлөөллийг хэрэгжүүлсэн байна.	Г
	1.12.Эрүүгийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг танилцуулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангуулах.	Санал гаргаж, шийдвэрлүүлсэн байна.	Г, Х
	1.13. Хууль, заавар, журмын хэрэгжилт, шалгалт, судалгааны дүнгийн талаар нэгж прокурорын газар, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад зөвлөмж, мэдээлэл, албан бичиг хүргүүлж, үр дүнг тооцох.	Үр дүнг тооцсон байна.	Г, Х, Ш
	1.14.Нэгж прокурорын газарт хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих.	Үндэслэл бүхий үүрэг даалгавар өгч, үр дүнг тооцсон байна.	Х, Ш
	1.15.Эрүүгийн хууль тогтоомж, хяналтын ажлын чиглэлээр мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох.	Хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, шийдвэрлэсэн байна.	Х, Ш
	1.16.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос өгсөн үүргийг хэрэгжүүлж, хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр хангах.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, мэдээллээр хангасан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих чиглэлээр		
	2.1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдоос гаргасан гомдлыг хуваарилах, шийдвэрлэлтэд хяналт тавих.	Хуульд заасан хугацаанд үндэслэлтэй шийдвэрлэсэн байна.	Х, Ш
	2.2.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэд хэдэн байгууллагын хамтарсан ажлын хэсэг байгуулах асуудлыг шийдвэрлэх, шийдвэрлүүлэх.	Ажлын хэсэг байгуулах асуудлыг шийдвэрлэсэн байна.	Г, Ш
	2.3.Гэмт хэргийн талаарх гомдол,		Х, Ш

	мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон прокурорын хяналтын харьяаллыг тогтоох.	Харьяаллыг үндэслэлтэй тогтоосон байна.	
	2.4.Мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж буй давхар хяналтад авсан хэргийн явц, үр дүн, шийдвэрлэлтийн байдалтай танилцаж, холбогдох арга хэмжээ авах	Хэргийн явц, үр дүнтэй танилцаж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Х, Ш
	2.5.Хэргийг давхар хяналтад авах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх прокурорыг томилох асуудлыг шийдвэрлэх.	Мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх прокурорыг томилсон байна.	Х, Ш
	2.6.Хяналтын ажлын аргачилсан зааварт заасан шуурхай мэдээлэх болон бусад шаардлагатай гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн талаар Улсын ерөнхий прокурор, түүний орлогчид тухай бүр танилцуулж, холбогдох арга хэмжээ авах.	Мэдээллээр шуурхай хангасан байна.	Г
	2.7.Эрүүгийн хэргийн тооллогын дүнг Улсын ерөнхий прокурорт танилцуулж, холбогдох арга хэмжээ авах.	Дүнг танилцуулсан байна.	Х
	2.8.Эрүүгийн хэрэгт олгох дугаарын хуваарилалтыг батлуулж, дугаар олголтод хяналт тавих.	Эрүүгийн хэргийн дугаар олголт нэг мөр хэрэгжсэн байна.	Х
	2.9.Прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэх.	Шийдвэрийг хуульд нийцүүлсэн байна.	Х, Ш
	2.10.Улс төрийн хилс хэрэгт шийтгэгдсэн болон баривчлагдан мөрдөгдсөн хүмүүст холбогдох эрүүгийн хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлаар шалгах ажиллагаанд хяналт тавих.	Хяналтыг хэрэгжүүлсэн байна.	Х, Ш
	2.11.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хариуцсан ажлын хүрээнд тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг нэгтгэн дүгнэх.	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.	Х, Ш
	2.12.Шүүх болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагатай ажил хэргийн уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах.	Ажил, арга хэмжээ нь үр дүнтэй зохион байгуулагдсан байна.	Г, Х, Ш
	Шүүхэд төрийг төлөөлөх ажлын чиглэлээр		

	2.13.Улсын Дээд шүүхийн эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох прокурорыг томилох.	Прокурорыг шүүх хуралдаанд оролцох нөхцөлийг хангасан байна.	Ш
	2.14.Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг нэг мөр хэрэглэхэд ач холбогдолтой, практик тогтоосон хяналтын шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, зөвлөмж, мэдээлэл гаргах, хэрэгжилтийг хангуулах.	Мэдээлэл, зөвлөмжийг хүргүүлсэн байна.	Х, Ш
	2.15.Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэрэг хэлэлцэх явцад илэрсэн мөрдөгч, прокурор, улсын яллагчийн гаргаж буй нийтлэг алдаа, зөрчилд дүгнэлт хийн мэдээлэл хүргүүлэх.	Мэдээллийг хүргүүлсэн байна.	Х, Ш
	2.16.Шүүх хуралдаанд оролцох улсын яллагч, прокурорт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг нэгтгэн зохион байгуулах.	Мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн байна.	Х
	2.17.Шүүх шийдвэрлэсэн олны анхаарал татсан, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн хэргүүдийн талаар тухай бүр Улсын ерөнхий прокурор, түүний орлогчид танилцуулах.	Мэдээллээр хангасан байна.	Г, Х
	2.18.Шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар гаргасан гомдлыг хуваарилах, шийдвэрлэх, танилцуулах.	Хуульд заасан хугацаанд үндэслэлтэй шийдвэрлэсэн байна.	Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Газар, хэлтсийн ажлыг уялдуулан зохион байгуулах, прокурор, ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих.	Ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна.	Х
	3.2.Газрын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг тооцох.	Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулсан байна.	Х, Ш
	3.3.Газрын хэмжээнд хяналтын ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлүүлж, хяналт тавих.	Бүртгэл хөтлөлтөд хяналт тавьсан байна.	Х
	3.4.Хяналтын ажилтай холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд хүргэх арга хэмжээ авах.	Мэдээ, мэдээллийг бэлтгэж, олон нийтэд хүргэсэн байна.	Х
	3.5.Газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, бодлого, зорилтыг уялдуулах.	Ажлын уялдаа холбоог хангасан байна.	Г, Х, Ш
	3.6.Газрын хэмжээнд хийж гүйцэтгэсэн ажлын мэдээ, тайланг гаргуулж, хяналтын ажлыг сайжруулахад чиглэсэн ажил, арга хэмжээг тодорхойлж хэрэгжилтийг хангах.	Мэдээ, тайланд үндэслэн ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Х, Ш

	3.7.Газар, хэлтсийн прокуроруудын хийх ажлын чиглэл, хариуцах нэгжийн хуваарийг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих.	Газрын чиг үүрэг бүрэн хэрэгжих нөхцөл бүрдсэн байна.	Х
	3.8.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х
	3.9.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эрх зүй (0421)	
Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Дээд шатны прокуророор 3-аас доошгүй жил, эсхүл Улсын ерөнхий прокурорын газарт ахлах прокуророор ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-газар, хэлтсийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдэлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны зөрэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачаалллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах; -албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

1.Улсын ерөнхий прокурор

2.Улсын ерөнхий прокурорын орлогч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
1. Газрын ахлах прокурор 2. Хэлтсийн дарга, ахлах прокурор 3. Газрын хяналтын прокурор 4. Хэлтсийн хяналтын прокурор 5. Газар, хэлтсийн туслах ажилтан 6. Аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, түүний орлогч 7. Аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих, шүүхэд төрийг төлөөлөх ажил хариуцсан прокурор Нийт: 7	1. Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага 3. Шүүх 4. Бусад төрийн байгууллага 5. Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар: А/95

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН

2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр